



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/75

Арвайхээр сум

**Д.Намширыг төрөлжсөн асрамжийн
үйлчилгээнд хамруулах тухай**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйл 19.4 дэх заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Хархорин сумын 1 дүгээр багийн харьяат Давгийн Намшир нь (йр64071579) 59 настай, төрсөн үр хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн тул улсын асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2.Дээрх иргэнийг нийгмийн халамжийн асрамжийн үйлчилгээнд хамруулахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах, иргэнийг улсын асрамжид хүргүүлэхэд гарах зардлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Нарангарав)-т үүрэг болгосугай.

ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0160